

СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРААС ХҮНИЙ НӨӨЦИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024.06.11

Баруун-Урт хот

Хүний нөөцийг чадавхжуулах, хүний нөөцийн ил тод байдлын талаарх хэрэгжүүлэх арга хэмжээ			
Д/д	Төлөвлөсөн ажил	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх	Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 64 тоот тушаалаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг батлан гаргасан. Тус газраас дээрх баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	90
2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх	Бодлогын баримт бичигт тулгуурлан байгууллагын өөрчлөлт хөгжил, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хувь хүн, удирдлагын мэдлэг мэдрэгжлийн ур чадварт тулгуурлан төлөвлөж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилласан.	100
3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх	Албан хаагчдыг сургах, хөгжүүлэх чиглэлээр албаны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, үр дүнд хүрсэн бодит ажлуудыг албан хаагчдын оролцойгоор хамтран зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинэлэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх талаар хүн бүрийн саналыг авч нэгтгэн тусгаж ажиллаж байна.	90
4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл	Бие бүрэлдэхүүнтэй улиралд тутамд Сахилгын зөвлөгөөнийг	100

	ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх	хийж, байгууллагын хөгжил, соён гэгээрүүлэх чиглэлээр хийх ажил, бие бялдарыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах спорт арга хэмжээ, зохиогдсон ажил арга хэмжээнүүдийн ололттой болон дутагдалтай талыг нээлттэй, ил тод ярилцаж, хамт олны саналыг сонсон, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллалаа. Зөвлөгөөнөөр байгууллагын соёл, үйл ажиллгаатай холбоотой санал шүүмжлэл байгаагүй	
5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх	ОБЕГ-аас ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг 2023 онд 2 удаа зарласан. Дээрх сонгон шалгаруулалтад тэнцсэн 11 иргэнийг ДХИС-ийн ахлагчийн сургуульд аврагч, гал сөнөөгч, дуудлага хүлээн авагч, гал унтраах автомашины жолооч мэрэгжлээр 2023 оны 3, 10 дугаар саруудад 3 сарын хугацаатай суралцуулж, ажлын байранд томилуулсан.	100
6	Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх	Онцгой байдлын газрын алба хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэж урамшуулсан.	100
	Биелэлтийн дундаж хувь		96,6